ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ
БАРИЛГА БАЙГУУЛАМЖТАЙ ГҮН ӨРМИЙН ХУДАГ ГАРГАХ, УСЛАЛТИЙН СИСТЕМ НИЙЛҮҮЛЭХ

А. Худаг шинээр гаргахын өмнө ба гарсны дараа үеийн гэрэл зургийг нэг цэгээс авч, худгийн солбицлыг нарийвлан тодорхойлсон байна.

*Б. Ажлын иж бүрдэл цооног өрөмдөх, цооногийг цэвэрлэх, шавхалт туршилтын ажил хийх, ус шахуурга сонгох, худгийн барилга барих, ус хадгалах сав насос, бетон суурь, холбох хэрэгсэл, цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах, /нарны/ цахилгаан эрчим хүчинд холбогдох ажлыг **MNS6088-2010** стандартын дагуу чанарын өндөр түвшинд гүйцэтгэнэ.*

В. Бүх бараа материал, тоног төхөөрөмж нь шинэ, баталгааны гэрчилгээтэй чанарын сертификаттай баталгаатай байна

- *Цэвэр усны шугам, хоолой, тоног төхөөрөмж, тоноглолууд нь ундны усны зориулалтаар ашиглах шаардлага хангасан байх.*
- *Ус түгээх хоолой нь хэрэглэгчид ус авхад хүндрэлгүй, хүйтэнд хөлдөж хагардаггүй, уян чанартай байх.*

Г. Монгол улсад мөрдөж буй хууль тогтоомж, стандарт, Хүнс, хөдөө аж ахуйн сайд, Байгаль орчны сайд, сангийн сайдын 2005 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 101/189/194 тоот хамтарсан тушаалаар баталсан "Инженерийн хийцтэй", худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах, нийтлэг журам"-ыг мөрдөнө.

Д. Худаг гаргах нутаг дэвсгэрийн нэр байршил:

***1. Баянхонгор аймгийн Баянговь сумын 1-р багийн ..... гэдэг** газарт цооног гаргана.*

Ажлын тоо хэмжээ

Д/д	Ажлын нэр
1	**Цооног өрөмдөх, цооногийг тоноглох**
1.1	Геофизикийн судалгаа хийж, худгийн байршлыг сумын ЗДТГ-тай зөвшилцөн эцэслэн тогтоож, БОАЖГ-аас зөвшөөрөл авсан байна.
1.2	Цооногийн ашиглалтын ундарга: Худгийн гүнээс хамаарч насосны хүчин чадлыг сонгох ба ундарга 0,8-2,0 л/с байна.
1.3	Худгийн өрөмдөх гүн хамгийн багадаа 60м, Гадуур нь хамгаалалтын барилгатай 2*2*2 харицаатай барилга байна.
1.4	Суултын яндангийн материал нь ган хоолой байна. ф 160 мм-ээс багагүй

1.5	Шүүрийн яндангийн материал нь ган хоолой байна. ф 160 мм-ээс багагүй /1м/м-80мм-ээс багагүй
1.6	Ус өргөх яндангийн ф 40мм- ээс багагүй, материал нь ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой буюу усанд зэвэрдэггүй ган яндан байна. /хүйтний улиралд тэсвэртэй/
1.7	Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцор хольцгүй,мөхлөгийн хэмжээ 1015мм-ээс томгүй байна.
1.8	Шүүрийн урт нь уст үеийн зузаанаас хамаарч худгийн ундарга 1,5 метрээс багагүй, тунгаагуурын урт 2м-ээс багагүй байна.
1.9	Худгийн цооног өрөмдлөгийн ажлын талаар мэдээллийг өрөмдлөгийн ажлын журналд тэмдэглэнэ.
1.10	Цоонгийн өрөмдлөгийн ажлыг дууссаны дараа шавхалтын ажлыг заавал хийж, шавхалтын ажлын журналыг дэлгэрэнгүй үйлдэнэ
1.11	Худгийг шавхалт хийж цооног цэвэршүүлэх хугацаа 24 цагаас багагүй байна.
1.12	Усны чанарын сорилт авч шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулсан байна.
1.13	Худгийн цооногийг тагаар битүүмжилж хамгаалсан байна.

2	Худгийн насос, бага оврын генератор, цахилгаан утас, хянах самбар, цахилгаан мотор 1ш.
2.1	Гүний насос: ISO9001 стандартын шаардлага хангасан, монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байна. үйлдвэрлэгчийн гарал үүслийн гэрчилгээтэй, зэвэрдэггүй ган төмөр байна.
2.2	Насосыг зориулалтын тороосоор бэхэлсэн /зэвэрдэггүй хамгаалалтай байна.
2.3	Цахилгааны утас 3 салаа, худагт ашиглах шаардлагыг хангасан, насосноос хянах самбар хүртэл үргэлжилсэн / залгаагүй/, ус өргөх янданд 2м тутамд хавчих /туузаар ороож болохгүй/ тогтооно.
2.4	Хянах самбар асаах унтраах товчлууртай, насос ажиллаж буйг /ногоон/, хүчдэл буйг /улаан/ гэрлээр асаах индикатортой, насос ажиллуулах асаагууртай
3.	**Худгийн ажлыг дуусгаж хүлээлгэж өгөх**
3.1	Талбайг цэвэрлэх / өрөмдлөгийн шлам, барилгын болон ахуйн хог хаягдал гэх мэт/
3.2	Худаг, гүний насос, цэвэршүүлэх төхөөрөмж ажиллуулах, үйлчилгээ хийх,

3.3	Худгийн өрөмдлөг, цооногийн хийц, шавхалт, тоног төхөөрөмжийг суурилуулах ажлыг MNS6088:2010 стандартын дагуу гүйцэтгэж баримтжуулсан материалыг сумын ЗДТГ-т хүлээлгэн өгнө.
3.4	Ашиглалтын цоонгийн техникийн паспортыг хөтөлж, аймгийн БОАЖГ-аар баталгаажуулан, сумын ЗДТГ, эзэмшигчид хүлээлгэн өгнө.

ХЯНАСАН:
ЗАСАГ ДАРГА Б.БАТ-АМГАЛАН

БОЛОВСРУУЛСАН:
АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ: Н.СУГАР-ЭРДЭНЭ
ГИШҮҮД: Ц.МӨНХТУЛГА
Б.НЯМЖАРГАЛ

БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯНГОВЬ СУМ НОГООН БАЙГУУЛАМЖИЙН УСЛАЛТЫН СИСТЕМ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2024 оны 08 дугаар сарын 26 Өргөн

Сумын төв "Хэлтгий булгийн" ар талд ногоон байгууламжийн усалгааны Гүн өрмийн худгаас 200м зайд байршилтай 50х200 харьцаатай хайс хамгаалалтад услалтын системийг байршуулах мөн 150м зайд байршилтай 1-га талбай руу мод усалгааны шланкыг тус тус хоёр талбайд байршуулах бөгөөд Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг усалгааны системийн тоног төхөөрөмж, эд ангийг нийлүүлж, угсралт хийсэн туршлагатай байж техникийн тодорхойлолтод заасан шаардлагын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгнө.

Хийж гүйцэтгэх /иргэн/ байгууллага

1. Бүх ажлуудыг тухай бүр нь хэмжилт хийж, фото зургаар баталгаажуулах .

Засаг даргын Тамгын газар

2. Гүйцэтгэлийн явцад Засаг даргын Тамгын газрын хяналтын ажлын хэсэг хяналт тавин ажиллана.

3. **Тохижилтын ажил: 1 дэх даалгавар**
   - ✓ Сумын төв Хэлтгий булгийн ар тал ногоон байгууламжийн усалгааны гүн өрмийн худгаас 250м зайд байршилтай өргөн 50м урт 200м талбайд услалтын систем хийнэ.
   - ✓ Услалтын системийн тоног төхөөрөмж усалгааны зориулалтын нар салхины нөлөөгөөр гэмтэх, хугарах, цоорох тоног төхөөрөмжийг сонгохгүй байх
   - ✓ 5-6 тонн ус нөөцлүүрийн сав 1 ш нь гадна орчинд тэсвэртэй, байгаль цаг уурын орчинд тохирсон сайн чанартай төмөр материалтай дүйцэхүйц байх.
   - ✓ Гүн өрмийн худгаас талбайд байх ус нөөцлүүрийн сав хүртэл 250м хоорондтөмөр юм уу дүйцэхүйц 70-тай хоолойгоор холболтыг газар доогуур хийнэ.
   - ✓ Ус нөөцлүүрийн савнаас услалтын системийн шугам нь тухайн 50х200м талбайг бүрэн услахаар байна.
   - ✓ Усалгааны гол шугамаас шуудуулж тарьсан мод сөөгийг туслах шугамуудаас крант нээж ус нь шууд урсгалаар урсаж усална, (тусал биш)

4. **Тохижилтын ажил: 2 дахь даалгавар**

- ✓ Сумын төв Хэлтгий булгийн ар талд ногоон байгууламжийн усалгааны гүн өрмийн худгаас 150м зайд байршилтай 1 га талбайд тарьсан мод сөөгийг услах усалгааны 250м шланкыг худгаас холболтоор гаргаж өгнө.
- ✓ Энэхүү шланкыг усалгаа хийх зориулалтаар ашиглагдаг.
- ✓ Солонгос Уян хатан чанар сайтай, хэрэглэхэд хялбар, гэрэл нэвтэрдэггүй хөгц болон төрөл бүрийн бичил биетэн дотор нь үржих боломжгүй, усны өндөр даралтыг тэсвэрлэх бат бөх бүтэцтэй 25 диаметртэй байна.
- ✓ Шаланк нь 50-100м хооронд холбогчоор холбох нөхцөлтэй хурааж авахад салгадаг шийдэлтэй байна.

✓ 3-4 тонн ус нөөцлүүрийн сав 1 ш нь гадна орчинд тэсвэртэй, байгаль цаг уурын орчинд тохирсон сайн чанартай төмөр материалтай дүйцэхүйц байх.

Услалтын системын ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгөх бөгөөд хэрвээ зураг төсөлд болон материал хийц зэргийг өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад албан бичгээр гаргаж хүсэлт гаргаснаар өдрөөс 2 хоногийн дотор хариуг шийдвэрлэнэ. Өөрчлөлтийг зөвшөөрлийн дагуу гүйцэтгэнэ.

Дээрх техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, ажлын явцад хяналт тавих ажлын хэсгийн эрхийнхээ дагуу ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

Мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн услалтын системийн тоног төхөөрөмийн тоо хэмжээ /1 га талбайд/

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо, хэмжээ /ш/
1	Шүүлтүүр 2	1
2	2 Муфть	2
3	500мм HDPE хоолой	200
4	16 мм дуслын хоолой 0,1мм, 20 см	10000
5	16мм гадас	200
6	50-16 хаалттай салаалагч	100
7	50мм булан	2
8	16 мм төгсгөгч	100
9	50мм тройник	3
10	50мм дундын хаалт	3
11	Дуслын холбогч	20

12	50мм төгсгөл	4
13	500мм, 1,5 квт, 220 вольт	1
14	50 мм эр холбогч	4
15	50мм хаалт	1

Зураг хавсаргав. Дуслын услалтын систем



ХЯНАСАН :
ДАРГА Б.БАТ-АМГАЛАН

БОЛОВСРУУЛСАН :
БОХУБ Ц.МӨНХТУЛГА
БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧ Б.НЯМЖАРГАЛ